

# Нүх

Дээр үеийн бичгийн машинуудаар үсэг бичихийн тулд харгалзах товчийг нэлээд хүчтэй дарах хэрэгтэй байдаг байсан.

Танд маш хурц ирмэг бүхий үсэгнүүдтэй бичгийн машин байгаа. 0 гэсэн цифрийг бичихэд цаасан дээр нүх гарах ба үсгэн дээр нь зууван хэлбэрийн цаас буцаж ирнэ. Үүнээс гадна 4, 6, 9 цифрүүд нэг нүх үүсгэх ба 8-ын тоо хоёр нүх үүсгэнэ. Бусад цифрүүд цаасыг зүсэх боловч нүх үүсгэхгүй.

Дээрх бичгийн машиныг ашиглан хоосон цаасан дээр яг  $h$  ширхэг нүх үүсгэхийн тулд хамгийн багадаа ямар сөрөг биш тоог бичих хэрэгтэй вэ? Олох тоо нь өмнөө тэгүүдийг агуулаагүй байна (өөрөө тэг байж болно).

## Input

Үүсгэх нүхний тоо  $h$  өгөгдөнө ( $0 \leq h \leq 510$ ).

## Output

Бичигдэх бүхэл тоо.

## Example

**Input:**

2

**Output:**

8

**Input:**

3

**Output:**

48

**Input:**

4

**Output:**

88

**Input:**

5

**Output:**

488

